


БАТЛАВ: БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. **Аудитын нэр:** “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”
2. **Аудитын код:** ГАГ-БНАТАГ-/2018/-01-ГА
3. **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт :

Аудитын явцад дараахь асуудалд гүйцэтгэлийн аудит хийж аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх
3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

5. “Аудитын хамрах хүрээ:

Аудитад орон нутгийн хөрөнгөөр 2017 онд батлагдан, хэрэгжсэн төсөл арга хэмжээг хамруулан аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар бусад хөрөнгө хүлээн авч ашиглагч байгууллагуудын санхүүгийн баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, холбогдох бусад материалуудаас авсан мэдээ, тайлан бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийнэ.

6. Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 4/2 тоот “Баянхонгор аймгийн 2017 оны төсвийн тухай”

тогтоолоор 2017 онд хэрэгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 26 ажилд 1950.0 сая төгрөгийг баталсан байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “**ДУНД**” гэж үнэлэв. /Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-ээс үзнэ үү/

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа гаргуулах, дүн, шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2,3-аас үзнэ үү/

8. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд :

Аудитын зорилттой холбогдуулан дараах хууль, тогтоомж, гэрээ хэлцэл, журам заавар, холбогдох бусад хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Монгол улсын төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль.
- 2017 оны төсвийн тухай хууль, аймгийн ИТХ-ын тогтоолоор Баянхонгор аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

9. Аудит хийх хугацаа:

Аудитын ажлыг 2018 оны 03 дүгээр сарын 21-ний өдрөөс эхэлж 04 дүгээр сарын 20-ны өдөр дуусгана.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Азбаяр нар хийж гүйцэтгэнэ.

11.Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

А. Боловсон хүчин 2*23=46 хүн өдөр


Б. Санхүүгийн нөөц: Цалин 2230,0 мянга, бичиг хэрэг 25,0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл Компьютер 2 ширхэг, бусад техник хэрэгсэл

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЦЭЦЭГМАА

БОЛОВСРУУЛСАН: АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА

АУДИТОР  Б.АЗБАЯР